



"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ



2015 онд олон нийтийг хамран зохион байгуулсан ажлууд

2015 он

1. "Эрүүл иргэн- Эко хөгжил" хөтөлбөрийн зуны арга хэмжээ /дугуйн аялал, амралт, зугаалгын хөтөлбөр/



Монголын дугуйн холбоо, Монголын үндэсний сурын холбоо, Монголын холч морин спортын холбоо болон дугуйн клуб, дэлгүүрүүдтэй хамтран дугуйн түрээс, засвар үйлчилгээний цэгийг амралтын өдрүүдээр Хүй долоон худагт ажиллуулав. Уг арга хэмжээнийд нийт 3000 гаруй хүүхэд залуус хамрагдлаа.

2. Талын салхи 2015 наадам



Монголын чопперчин ахан дүүс ТББ-аас санаачлан мото спорт сонирхогч 400 гаруй тамирчид мөн ОХУ-аас төлөөлөлүүд хүрэлцэн ирж 2500 гаруй сонирхогчид цуглан Хүй долоон худагт анхны наадмаа хийлээ.

3. Сонгинохайрхан дүүргийн иргэдийн баяр



Сонгинохайрхан дүүргийн тамгын газраас зохион байгуулдаг Иргэдийн баярны арга хэмжээ нь тус дүүргийн 32 хороо тус бүр гэр барин бөхийн барилдаан, хурдан морины уралдаан зохион байгуулан 2000 гаруй иргэдээ хамруулан оролцлоо.

4. Үндэсний Их Баяр Наадам 7 сарын 10-15



Жил бүрийн Үндэсний их баяр наадмаар Хүй долоон худагт 700 гаруй уяач, зургаан насны 2000 орчим морьд, 70-150 мянган наадамчид цуглардаг ба үүнээс зөвхөн 7 сарын 12-нд үзэгч, олон нийтийн хамгийн ихээр үздэг Соёолон насны морины уралдаан болдог ба ойролцоогоор 120-150 мянган наадамчид, наадмын 4 өдрийн турш ойролцоогоор хот, орон нутгаас нийтдээ 300-350 мянган хүн /давхардсан тоогоор/ цуглардаг гэсэн албан бус тоо байна.

5. Адуучин 2015 тэмцээн



Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагддаг “Адуучин” тэмцээнийг энэ удаа “Монголын адуучдын холбоо” хамтран зохион байгууллаа. Монгол Улсын шилдгийн шилдэг уран уургач, бугуйлч, эмнэг, хангал сургагчийг шалгаруулдаг "Адуучин-2015" тэмцээн 2015 оны 7 дугаар сарын 14-нд Хүйн долоо худагт амжилттай болж өндөрлөлөө.

6. “Баянгол номатик фестиваль”

VIII сар 18 өдөр



50 жилийн түүхтэй Нийслэлийн Баянгол дүүргийн иргэд ойн баяр наадамд 128 хүчит бөх барилдаж, азарга, их нас, соёолон насны шандаст хурдан хүлгүүд уралдаж, эрхийн мэргэн харваачид цэц мэргэнээ сорилоо. Мөн энэ үеэр “Дээлтэй монгол” наадам зохион байгуулагдаж шилдэг монгол дээлтэй хосыг шалгаруулсан ба дугаар ангийн цэрэг эрс тулааны гайхамшигт үзүүлбэрийг наадамчин олонд толилуулсан юм.

7. “Хүрээ цам Даншиг наадам”



Нийслэлийн засаг даргын тамгын газар Төв Гандантэгчилэн хийдтэй хамтран Найрсаг Улаанбаатар төслийн хүрээнд үндэсний өв соёлоо сурталчилсан гадаад, дотоод жуулчдыг татах зорилгоор уг наадмыг хамтран зохион байгуулав. Наадмаар Үндэсний бөхийн барилдаан болж түрүү бөхөд Даншигийн Арслан цол олголоо мөн хурдан морины уралдаан боллоо. Наадмын үеэр 50,000 гаруй наадамчид, 600 гаруй гадаадын жуулчин Хүй долоон худагт цуглаж наадлаа.



8. Айрагны баяр /Айраг фестивалы/



Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ болон Хаадын зам жуулчны бааз хамтран Даншиг наадмын үеэр “Айрагны баяр “ зохион байгуулав. Энэ баяраар Дэмбээ, Хурууны тэмцээн, хэн сайн айраг уух бэ тэмцээнүүд явагдлаа. Тэмцээнд 150 гаруй наадамчид оролцлоо.

9. УБЦТС ХК-ын баяр



Жил бүрийн 8 сарын 15-ний өдөр Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ компани Ажилчдын баярын арга хэмжээгээ Улаанбаатар хотын 9 дүүргийн хамт 1500 гаруй ажилчин албан хаагчдын хамт Хүй долоон худагт тэмдэглэн өнгөрүүлдэг. Уг арга хэмжээний үеэр Үндэсний нум сумын харваа, Үндэсний бөхийн барилдаан, Урлагийн үзлэг зэрэг олон сонирхолтой арга хэмжээ болж өнгөрлөө.